

IV-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 09




## Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх улирлаас 25-аар нэмэгдлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2021 оны 2 дугаар улиралд 70 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 13 (18.6%)-аар буурсан байна. Харин өмнөх улирлаас 25 (35.7%) -ээр өссөн байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 22 (31.4%) тохиолдол унах бүдрэх, хальтарснаас үүссэн бол унаж байгаа эд зүйлд цохигдох 11 (15.7%), эд зүйлд хавчуулагдах 9 (12.9%), гадны халдлагад өртөх 5 (7.1%), эд зүйл дээр гишгэх суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдох 3 (4.3%), халалт, түлэгдэлт, хөлдөлт 2 (2.9%), хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн 1 (1.4%), цахилгаан гүйдэлд цохиулах 1 (1.4%), живэх 1 (1.4%), бусад 15 (21.4%) тохиолдол бүртгэгдсэн байна.


Нийт осолдогчдын 33 (47.2%) нь хөнгөн хэлбэрээр, 32 (45.7%) хүнд хэлбэрээр осолдож, 5 (7.1%) хүн нас барсан байна.

Зураг-1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, бүсээр, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар



Нийт осолдогчдын 16 (22.9%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2021 оны 2-р улиралд Баруун бүс 6 (8.6%), Хангайн бүс 6 (8.6%), Төвийн бүс 7 (10.0%), Зүүн бүс 12 (17.0%), Улаанбаатар хотод 37 (52.9%), бусад буюу Улаанбаатар төмөр замд 2 (2.9%) тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг-2. Осолдогчид, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар улиралд




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 14 хүртэлх насных 2 (2.9%), 18-24 насных 10 (14.3%), 25-34 насных 24 (34.3%), 35-44 насных 17 (24.3%), 45-59 насных 16 (22.9%), 60 ба түүнээс дээш насных 1 (1.3%) байна.

Хүснэгт-1. Осолдогчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн 2 дугаар улиралд

Салбар	2019 IV-VI	2020 IV-VI	2021 IV-VI
<b>Дүн</b>	<b>70</b>	<b>83</b>	<b>70</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	2	4
Уул уурхай, олборлолт	12	17	9
Боловсруулах үйлдвэрлэл	8	7	7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	1	2
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	12	2	6
Барилга	8	11	11
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	-	-	3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	7	5	4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	1	1
Мэдээлэл, холбоо	1	2	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4	2	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1	16	8
Боловсрол	3	1	1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	5	10	6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4	5	7

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр авч үзвэл, энгийн ажил мэргэжилтэн 27 (38.6%), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 15 (21.4%), Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 9 (12.9%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 5 (7.1%), зэвсэгт хүчний ажил, мэргэжил тус 5 (7.1%), мэргэжилтэн 4 (5.7%), контор, үйлчилгээний ажилтан 3 (4.3%), худалдаа, үйлчилгээний ажилтан 1 (1.4%), менежер 1 (1.4%) байна.

Зураг-3. Осолдогчид, ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар улиралд



## Ойлголт, тодорхойлолт:

**Үйлдвэрлэлийн осол:** гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

**Хурц хордлого:** гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

**Осолдогч:** гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

**Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан,** иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

**Бүлэг осол, хурц хордлого:** гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.

**Эх үүсвэр:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

**Ангилал, код:** ISCO-08 - ажил, мэргэжлийн ангилал, ISIC-4 - эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ICD-10- өвчний олон улсын ангилал.



## **Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 10 дугаар сарын 15

Хүн ам, нийгмийн статистикийн  
газрын гэрээт ажилтан Н. Алтантүлхүүр  
Утас : (976-51)-265543

Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга  
А.Амарбал  
Утас : (976-51)-264805



@StatisticMongolia



@statistic\_mn



information@nso.mn



Лавлах утас 1900-1212